



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 14 өдөр

Дугаар Д/130

Хэрлэн сум

**Иргэн цэргийн харилцааг бэхжүүлж,  
хүүхэд, залуучуудад цэрэг эх оронч үзэл төлөвлшүүлэх  
арга хэмжээнд хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.10, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хорин гуравдугаар хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 02 дугаар тогтоол, "Монгол Улсын Засгийн газрын Батлан хамгаалах зарим чиг үүргийг Хэнтий аймагт төлөөлөн 2024 онд хэрэгжүүлэх гэрээ"-ний 1.6 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. "Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвлшүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулж, цэргийн насны болон өсвөр насны иргэдийн дунд цэрэг-эх оронч хүмүүжил олгоход чиглэсэн арга хэмжээнүүдийн тусгай төлөвлөгөө гарган зохион байгуулахад 8.000.000 (найман сая) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрхи үйл ажиллагааны зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2024 оны  
0.3 дугаар сарын...-ны  
А/130 дугаар захирамжийн хавсралт

ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Үйл ажиллагааны нэр	Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Хянасан
1	ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад цэрэг эх оронч үзэл төлөвлшүүлэх аяны хүрээнд зохион байгуулагдах сагсан бөмбөгийн тэмцээний зардалд	1	300.000	300000	
2	Ахмад залуу үеийн хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор зохион байгуулагдах уулзалт, зөвлөгөөний зардалд	3	400,000	1200000	
3	Халхын голын байлдааны ялалтын 85 жилийн ойн арга хэмжээний хүрээнд хүүхэд, залуучуудад чиглэсэн үйл ажиллагааны зардалд	3	1.000.000	3000000	
4	"Бидний бахархал" төслийн үйл ажиллагааны 2 дугаар шатны арга хэмжээ Мөрөн, Өлзийт, Жаргалтхаан, Цэнхэрмандал, Бор-Өндөр, Дархан, Баянмөнх сумдад зохион байгуулах зардал	7 хоног сумдад ажиллах томилолтын зардал 3 хүнээр	64	1344000	
5	Шатахууны зардал АЙ92 бензин	Сумдад ажиллах бензиний зардал 180л	2520	453600	
6	Халхын голын байлдааны ялалтын 85 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдах тойрон аялалын зардал	1	2.002.400	2002400	
<b>Нийт</b>				<b>8,000,000</b>	